ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 07 өдөр Дугаар А/01 Өлзийт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1., 59.1.23 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/744 дүгээр захирамжаар батлагдсан "Аймгийн аварга малчин өрх шалгаруулах журам"-ын 2, 3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн аварга малчин өрх шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Л.Гантулга (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд О.Дэжидмаа (Ерөнхий нягтлан бодогч)
Б.Баярхүү (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)
Л.Мягмар (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)
Т.Пүрэв (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

2.Аймгийн аварга малчнаар шалгаруулсан малчдын материалыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хугацаанд нь бүрдүүлж хүргүүлэхийг Хөдөө аж ахуйн мэргэжилтэн (Л.Мягмар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601001

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 07 өдөр Дугаар А/03 Өлзийт сум

Цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн "Цэргийн бүртгэл явуулах журам батлах тухай" А/331 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2026 оны цэргийн шинэчилсэн бүртгэлийг явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч Л.Гантулга (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: В.Аюушжав (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Ц.Доржсэмбэ (1 дүгээр багийн Засаг дарга)

Ж.Пүрэвсүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

Л.Намдаг (3 дугаар багийн Засаг дарга)

Н.Цэрэнтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)

2.Цэргийн 2026 оны шинэчилсэн бүртгэлийг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 01 дүгээр сарын 19-ны өдрийг хүртэлх хугацаанд сумын Засаг даргын Тамгын газарт биечлэн болон цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

3.Цэргийн бүртгэлийг үнэн зөв явуулахад мэргэжлийн удирдлага, туслалцаа үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж тогтоосон хугацаанд тайлан мэдээг нэгтгэж аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 09 өдөр Дугаар А/03 Өлзийт сум

Нууц бичиг баримтын тооллого явуулах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар 6.3, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 246 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 5.10 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Нууцын ажилтан Л.Гантулга)-д хадгалагдаж байгаа "Нууц бичиг баримт"-ыг тоолох комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын ахлагч: Э.Энхбаяр (Засаг даргын орлогч)
Гишүүдэд: В.Аюушжав (Хууль эрх зүйн дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн)
М.Цэрэнханд (Архив, бичиг хэргийн ажилтан)

2.Комисст ДААЛГАХ нь:

а) Нууц бичиг баримтуудын он, сар, дугаар, нууцын зэрэглэл, хуудасны тоо зэргийг нэг бүрчлэн хуучин бүртгэлтэй нь тулган шалгаж тооллогын бүртгэл үйлдэх.

3.Нууц бичиг баримтын хадгалалт, хамгаалалт ямар байгаад дүгнэлт хийж тооллогын дүнг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны дотор танилцуулахыг комиссын ахлагч (Э.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ӨНЧИГ

Alban hereg hutlult-026

622601005

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 12 өдөр Дугаар 9/05 Өлзийт сум

Дотоод журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1, 122,2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын засаг даргын Тамгын газрын дотоод журмыг хавсралтаар батлалсугай.

2.Дотоод журмын хэрэгжилтэд, хяналт тавьж журмыг мөрдүүлэхтэй холбогдсон арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Гантулга)-д даалгасугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/38 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601013

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 14 өдөр Дугаар 23/06 Өлзийт сум

Төсвийн сар улирлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа,нутаг дэвсгэрийн нэгж,түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1,Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт,Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн "Төсвийн сар,улирлын хуваарь батлах тухай" 281 дүгээр тушаал,Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2026 оны төсөв батлах тухай" 2025 оны 12 дугаар сарын 18 ний өдрийн 07/10 дугаар тогтоолыг тус,тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын санхүүгийн дэмжлэгийн сар, улирлын хуваарийг нэгдүгээр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сар, улирлын хуваарийг хоёрдугаар, Засаг даргын Тамгын газрын сар улирлын хуваарийг гуравдугаар, сумын татварын болон татварын бус орлогын сар улирлын хуваарийг дөрөвдүгээр, Ерөнхий боловсролын сургуулийн сар улирлын хуваарийг 5 дугаар хавсралтаар, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сар улирлын хуваарийг 6 дугаар хавсралтаар, Эрүүл мэндийн төвийн сар улирлын хуваарийг 7 дугаар хавсралтаар, Соёлын төвийн сар улирлын хуваарийг 8 дугаар хавсралтаар тус тус баталсугай

2.Төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгож, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн ерөнхий нягтлан бодогч (О.Дэжидмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ө.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601015

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 09 өдөр Дугаар А/07 Өлзийт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн хоол, хүнсний материал нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга П.Оюунцэцэг (Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч)
Нарийн бичгийн дарга Д.Цэрэндолгор (Сум хариуцсан халамжийн ажилтан)
Гишүүд: Л.Мягмар (Малын үржил, бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
В.Аюушжав (Хууль эрх зүйн дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн)
Д.Чулуундорж (Насан туршийн боловсролын арга зүйч)

2.Төрийн болон Орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хорооны дарга (П.Оюунцэцэг)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Цэрэндолгор)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601020

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 10 өдөр Дугаар 07/08 Өлзийт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 2.1.5, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 07/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2025 оны үйл ажиллагаагаар тэргүүний байгууллага, баг, ажилтан, ажилчин, сумын аварга малчин, аж ахуйн нэгж, аваргуудыг хавсралтаар баталж шагнасугай.

2. Шагналд зарцуулагдах 6,434,000 (зургаан сая дөрвөн зуун гучин дөрвөн мянган төгрөгийг) сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Т.Пүрэв)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ТОНЧИГ

622601023

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 16 өдөр Дугаар А/09 Өлзийт сум

Сумын "Алдарт уяач" цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 10 дугаар зүйлийн 10.6 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Адуун сүргийнхээ хурдан удмыг сайжруулах, зохион байгуулсан баяр наадмын хурдан морьдын уралдаанд гаргасан морин спортын амжилтуудыг нь үндэслэж 1 дүгээр багийн уяач Бавуугийн Бадамдорж, 2 дугаар багийн уяач Дэмбэрэлийн Наранмандах, Сумьяагийн Сүхбаатар, Дондогийн Сэдэд, 3 дугаар багийн уяач Гончигийн Санжаа, нарт сумын "Алдарт уяач" цол олгосугай.

2. Сумын алдарт уяачийн үнэмлэх, тэмдэг олгож шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг (Уяачдын холбоон дарга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601029

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 16 өдөр Дугаар А/10 Өлзийт сум

Эргүүл жижүүр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаврын тэргүүн сар шинийн баяр тохиож байгаатай холбогдуулан 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 02 дугаар сарын 24-ны өдрүүдэд ажиллах эргүүл жижүүрийн хуваарийг хавсралтаар батлсугай.

2.Эргүүл жижүүрийн ахлагч нарт ДААЛГАХ нь:

а) Уурын зуух, холбоо, цахилгаан шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангаж үйл ажиллагаанд нь байнгын хяналт тавьж цахилгааны тасалдал, гэмтэл, осол, дулааны шугам хөлдөлт зэрэг гэмтэл гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах.

б) Байгаль цаг агаарын гэнэтийн аюул, цасан болон шороон шуурга, цочир хүйтрэлт зэрэг гамшгийн аюул тохиолдож болзошгүй талаар хөдөөгийн багууд, албан байгууллагын ажилтнууд, иргэд, малчдад байнгын мэдээлэл өгөх.

в) Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, архидан согтуурсны улмаас гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргаж болзошгүй иргэдийг анхааралдаа авч хяналт тавих.

г) Жижүүрийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг жижүүрийн дэвтэрт дэлгэрэнгүй бичиж дараагийн жижүүрт албан ёсоор хүлээлгэж өгөх.

д) Гадна дотроос явж байгаа машин, зорчигч нарын хөдөлгөөнд хяналт тавьж ажиллах

3.Шинэ сарын өдрүүдэд байгууллага дээр эргүүл жижүүр тогтмол ажиллуулахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4.Эргүүл жижүүрийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж тайлан мэдээллийг нэгтгэж захирамжийн биелэлтийг 2026 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 10:00 цагт Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд танилцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Гантулга), Цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Ч.Хорол) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601031

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 06 өдөр Дугаар А/11 Өлзийт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Вэб сайтын хугацаа дууссан тул сайтыг нээлгэх зардалд 800,000 (найман зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Вэб сайтын сунгалтын үнэ 800,000 (найман зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Т.Пүрэв)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601036

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 12 өдөр Дугаар А/12 Өлзийт сум

Хязгаарлалтын дэглэм тогтоож, мэргэжлийн
баг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 1 дүгээр багийн малчин З.Чадраабал (46.6607 103.1741), Г.Пунцагцэрэн (46.6437 103.1880), Ч.Ганбямба (46.6503 103,1974) нарын хонь, үхэрт шүлхий өвчний сэжиг илэрсэн тул сумын Мал эмнэлгийн саналыг үндэслэн 5 км радиуст голомтын бүс тогтоож 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Тандалт хийх байршил, хязгаарлалтын дэглэмийн үед ажиллах мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулсугай.

3.Дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт байгаа малтай өрхүүдийн малд тандалт шинжилгээ хийж, дархлаажуулалтын ажил болон халдваргүйжүүлэлтийг яаралтай зохион байгуулж ажиллахыг сумын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт, малчдад шүлхий өвчний талаар сэрэмжлүүлэг, мэдээлэл хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4.Хязгаарлалтын дэглэмийн үеэр байнгын хөдөлгөөнт эргүүл гаргаж техник хэрэгсэл, хүн, хүч дайчлан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Гантулга), шаардагдах бензин шатахууны зардлыг малын тоо толгойн албан татварын зардлаас зарцуулахыг Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Дэжидмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (Д.Лхамжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601039

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 17 өдөр Дугаар А/18 Өлзийт сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, 51 дүгээр зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2026 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 26-1805, 26-1806 тоот шинжилгээний дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 1 дүгээр багийн нутаг Баянхошууны малчин З. Чадраабал, Давхарын малчин Ч. Ганбямба нарын УМЭАЦТЛ-ийн 2026 оны 3 дугаар сарын 16-ний өдрийн 26-1805, 26-1806 дугаартай шинжилгээний дүнгээр малын гоц халдварт шүлхий өвчин оношлогдсон тул Мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийн үеийн бүсүүдийн хилийн заагийг тогтоосон тойм зургийг 1-р хавсралтаар, дэглэмийн үед ажиллах Мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг малын эмч (Д.Лхамжав)-аар ахлуулан 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хорио цээрийн дэглэмийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулан хүч хэрэгслийг зөв хуваарилан оролцуулж, голомтын бүсийн заагт тасралтгүй ажиллагаатай хяналтын цэгийн байршлыг тогтоож, сэжигтэй бүсийн заагт хөдөлгөөнт эргүүл ажиллуулан мал, амьтан, хүн, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор хорио цээрийн арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг сумын Засаг даргын орлогч, Мэргэжлийн ангийн дарга (Э.Энхбаяр)-д,

4.Хорио цээрийн дэглэмийн үед мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврын дагуу мал эмнэлгийн цогц арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, халдварт өвчний цагийн байдлын мэдээллээр холбогдох газруудыг ханган ажиллахыг Мэргэжлийн багийн ахлагч (Д.Лхамжав)-д,

Alban hereg hutlult-026

622601041

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 17 өдөр Дугаар А/144 Өлзийт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 ба 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн зөөлөн эдлэл нийлүүлэх ажлын тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: О.Дэжидмаа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч
Гишүүд: Д.Чулуундорж (Иргэний төлөөлөл)
Д. Д.Амарсанаа (Цэцэрлэгийн эрхлэгч)
В. Аюушжав (Хууль эрх зүйн мэргэжилтэн)
Нарийн бичиг: П. Оюунцэцэг (Сургуулийн нягтлан бодогч)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (О.Дэжидмаа)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (П. Оюунцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601043

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 4 өдөр Дугаар 21/15 Өлзийт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн, ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хийж нийлүүлэх ажлын тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: О.Дэжидмаа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Гишүүд: П. Оюунцэцэг (Сургуулийн нягтлан бодогч)
Д. Цэрэндолгор (Халамжийн мэргэжилтэн)
Б.Баярхүү (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)
Нарийн бичиг: В. Аюушжав (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (О.Дэжидмаа)-нд даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (В. Аюушжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601045

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 03 сарын 17 өдөр Дугаар А/16 Өлзийт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгыг пасадлах ажлын тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Баярхүү (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Гишүүд: Д.Чулуундорж (Иргэний төлөөлөл)
В. Аюушжав (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)
П. Оюунцэцэг (Сургуулийн нягтлан бодогч)
Нарийн бичиг: Д.Амарсанаа (Цэцэрлэгийн эрхлэгч)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Баярхүү)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Д.Амарсанаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601047

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 18 өдөр Дугаар А/17 Өлзийт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрүүл мэндийн төвийн хэвтэн эмчлүүлэгч нарын хоол, хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Баярхүү (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Гишүүд: В.Аюушжав (Хууль эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн)
Д.Чулуундорж (Иргэний төлөөлөл)
Д.Амарсанаа (Цэцэрлэгийн эрхлэгч)
Нарийн бичиг Д. Цэрэндолгор (халамжийн мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (О.Дэжидмаа)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Д. Цэрэндолгор)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601049

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 18 өдөр Дугаар А/18 Өлзийт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай, дотуур байрны сурагчдын хоол, хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Цэрэндолгор (Халамжийн мэргэжилтэн)
Гишүүд: В.Аюушжав (Хууль эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн)
Б.Баярхүү (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Д.Амарсанаа (Цэцэрлэгийн эрхлэгч)
Нарийн бичиг Д.Чулуундорж (Насан туршийн боловсролын арга зүйч)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Д.Цэрэндолгор)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Д.Чулуундорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601051

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 19 өдөр Дугаар А/19 Өлзийт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, 51 дүгээр зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2026 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 26-1805, 26-1806 тоот шинжилгээний дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг Бор хошууны 1 дүгээр багт малын гоц халдварт шүлхий өвчин батлагдаж хорио цээрийн дэглэм тогтоосон тул бүсэд ажиллаж байгаа мэргэжлийн баг, постод гарч байгаа албан хаагч нарын ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, шатахуун, хоол хүнсэнд зориулж 5,000,000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг малын тоо толгойн албан татварын зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Т.Пүрэв)-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601062

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 10 өдөр Дугаар 2/01 Өлзийт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон Орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1 50.2, Захиргааны ерөнхий хуулийн 43,46 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд Хөдөө аж ахуйн газар тариалангийн тонон төхөөрөмж нийлүүлэх аж ахуй нэгжийг сонгон шалгаруулах ажлын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч : Б.Баярхүү (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Гишүүд: Л.Мягмар (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)
Д.Чулуундорж (Иргэний төлөөлөл)
П. Оюунцэцэг (Сургуулийн нягтлан бодогч)
Нарийн бичгийн дарга: В.Аюушжав (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

2.Төрийн болон Орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Баярхүү)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг нарийн бичгийн дарга (В.Аюушжав)- д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА З.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601059

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 20 өдөр Дугаар А/40 Өлзийт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон Орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1 50.2, Захиргааны ерөнхий хуулийн 43,46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүн өрмийн худгийн цооног гаргах ажлыг гүйцэтгэх аж ахуй нэгжийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч : О.Дэжидмаа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Нарийн бичгийн дарга: Д.Цэрэндолгор (Халамжийн мэргэжилтэн)
Гишүүд: П.Оюунцэцэг (Сургуулийн нягтлан бодогч)
Д.Чулуундорж (Иргэний төлөөлөл)
Нарийн бичгийн дарга Л. Мягмар (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

2.Төрийн болон Орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (О.Дэжидмаа) -д даалгасугай .

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтосмжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг нарийн бичгийн дарга (Л.Мягмар)- т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601056

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 10 өдөр Дугаар 31/22 Өлзийт сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2027 онд хийгдэхээр багийн иргэдээс авсан саналыг багийн Иргэдийн нийтийн Хурлаар хэлэлцэж ирүүлсэн саналыг эрэмбэлэх сумын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Гантулга (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд: О.Дэжидмаа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Л. Мягмар (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)
Б. Баярхүү (Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн)
Л.Жаргалсайхан (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)
А.Ариунбадрал (Цаг уурын харуул)
А. Бадам (Иргэний төлөөлөл)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2027 онд хийгдэх ажлыг багуудаас ирсэн саналыг Төсвийн тухай хууль, Монгол Улсын Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалар батлагдсан журмын дагуу эрэмбэлсэн сумын иргэдийн төлөөлөгчдийн Хуралд оруулж танилцуулан батлуулахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601054

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 31 өдөр Дугаар А/088 Өлзийт сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль-ийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны "Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналт тавих тухай", 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны " Мал амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай" 225 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай" А/134 дугаар захирамж, Мал эмнэлгийн газрын даргын 2026 оны "Аймгийн хэмжээнд шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөө, удирдамж батлах тухай" А/09, "Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах" А/16 тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд мал сүргийг гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдваргүйтгэлийн арга хэмжээг 2026 оны 04 дугаар сарын 01-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, товлосон хугацаанд мал сүргийг бэлэн байлгах үүрэгийг багийн Засаг дарга нарт, хэрэгжилтэнд тогтмол хяналт тавих, гоц халдварт өвчний вакцинжуулалт, халдваргүйтэглийн ажилд шаардагдах зардлыг шийдвэрлэж, тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг сумын Ерөнхий нягтлан бодогч (О.Дэжидмаа), Засаг даргын тамгийн газрын дарга (Л.Ганчулга) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулагдах тарилгыг цаг хугацаанд нь татан авч, хувийн мал эмнэлэг, үржилгээний нэгжүүдэд хүргэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц, чанар үр дүнтэй уялдуулан

Alban hereg hutlult-026

622601069

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 31 өдөр Дугаар А/134 Өлзийт сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль-ийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.3.3, 7.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналт тавих тухай" 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны "Мал амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай" 225 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны 3-р сарын 3-ны өдрийн "Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай" 01/20 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай" А/134 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал эмнэлгийн газрын даргын 2026 оны "Аймгийн хэмжээнд шимэгчтэх өвчнийг эмчлэн сэргийлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөө, удирдамж батлах тухай" А/ дүгээр тушаал, "Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах" А/13 дугаар тушаал, "Мал эмнэлгийн идэвхгүй тандалт зохион байгуулах төлөвлөгөө батлах тухай" А/15 дугаар тушаал, "Орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" тушаалын дагуу сумын хэмжээнд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг тус тус зохион байгуулсугай.

2.Мал эмнэлгийн ажил үйлчилгээг товлосон хугацаанд чанартай шуурхай хэрэгжүүлэн ажиллахыг "Зөсхангай", "Баянханхал", "Баяндалайн баялаг " мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд үүрэг болгосугай

3.Багийн малчдад мал эмнэлгийн ажлын зар, мэдээллийг цаг тухайд нь хүргэж, хариуцсан багийн мал сүргийг тогтоосон хугацаанд бэлэн байлгаж, бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Гоц халдварт өвчний вакцинжуулалт, мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах зардлыг шийдвэрлэж, тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О. Дэжидмаа), Мал эмнэлгийн тасгийн үүргийн түр орлон гүйцэтгэгч (Д. Лхамжав) нарт үүрэг болгосугай.

Alban hereg hutlult-026

62601071

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 02 өдөр Дугаар А/25 Өлзийт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтныг Микробиологийн аргаар устгах ажилд зориулж 7,000,000 (долоон сая) төгрөгийг зарцуулсугай

2.Дээрх ажилд зарцуулах 7,000,000 (долоон сая) төгрөгийг Малын тоо толгойн албан татвараас зарцуулахыг нягтлан бодогч (Т.Пүрэв)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГӨНЧИГ

Alban hereg hutlult-026

622601073

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 06 өдөр Дугаар 01/26 Өлзийт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам" 2.1.3, 2.1.5, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Засаг даргын Тамгын газраас 2025 онд зохион байгуулагдсан арга хэмжээний үлдэгдэл өр 2,000,000 (хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Арга хэмжээнд зарцуулагдсан 2,000,000 (хоёр сая) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нягтлан бодогч (Т.Пүрэв)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601076

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 27 өдөр Дугаар 9/227 Өлзийт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 9 дүгээр 9.4, 9.5 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн нутаг Сахилдагтайд хаваржиж байгаа малчин Б.Насанбатын хонинд цэцэг өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн тул малыг вакцинжуулах, хяналт тавих ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Мягмар (хөдөө аж ахуйн мэргэжилтэн)
Гишүүд: Ж.Пүрэвсүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
Д.Чойжав (Баян ханхал мал эмнэлгийн малын эмч)

2. Нутаг дэвсгэрт байгаа малтай өрхүүдийн малд тандалт судалгаа хийж, дархлаажуулалтын ажил болон халдваргүйжүүлэлтийг яаралтай зохион байгуулж ажиллахыг малын эмч (Д.Чойжав), малчдад бог малын цэцэг өвчний талаар урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээг хүргэж ажиллахыг багийн дарга (Ж.Пүрэвсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын хөдөө аж ахуйн мэргэжилтэн (Л.Мягмар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Э.ЭНХБАЯР

Alban hereg hutlu[illegible]26

622601081

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 11 өдөр Дугаар А/28 Өлзийт сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, 51 дүгээр зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2026 оны дугаар сарын 11-ны өдрийн 26-2269 тоот шинжилгээний дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2 дугаар багийн малчин Б. Насанбатын хонинд УМЭАЦТЛ-ийн 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 26-2269 дугаартай шинжилгээний дүнгээр малын гоц халдварт цэцэг өвчин оношлогдсон тул, Мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн 2026 оны 3 дугаар сарын 11-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийн үеийн бүсүүдийн хилийн заагийг тогтоосон тойм зургийг 1дүгээр хавсралтаар, дэглэмийн үед ажилгаа Мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг малын эмч Д.Лхамжаваар ахлуулан 2 дугаар хавсралтаар, хөдөлгөөнт эргүүлд ажиллах албан хаагч нарыг 3 дугаар хавсралтаар тус баталсугай.

3. Хорио цээрийн дэглэмийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулан, хүн, хэрэгслийг зөв хуваарилан оролцуулж, голомтын бүсийн заагт тасралтгүй ажиллагаатай хяналтын цэгийн байршлыг тогтоож, сэжигтэй бүсийн заагт хөдөлгөөнт эргүүл ажиллуулан мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавих зэргээр хорио цээрийн арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Гантулга)-д даалгасугай.

4.Хорио цээрийн дэглэмийн үед мал, амьтны гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврын дагуу мал эмнэлгийн цогц арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, халдварт өвчний цагийн байдлын мэдээллээр холбогдох газруудыг ханган ажиллахыг Мэргэжлийн багийн ахлагч (Д.Лхамжав)-д үүрэг болгосугай .

5. Хорио цээрийн дэглэм тогтоосон бүс нутагт малын шилжилт хөдөлгөөнийг бүрэн зогсоож, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах,

Alban hereg hutlult-026

622601083

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 16 өдөр Дугаар А/109 Өлзийт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 02 өдөр Дугаар 01/68 Өлзийт сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 32 дугаар зүйлийн 32.1.2, 51 дүгээр зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийнз 17.2.1, 18 дугаар зүйлийн, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 26-3348 тоот шинжилгээний дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн малчин О.Амгаланбаатар, Д.Жамба нарын хонинд УМЭАЦТЛ-ийн 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 26-3348 дугаартай шинжилгээний дүнгээр малын гоц халдварт Шүлхий өвчин оношлогдсон тул, Мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийн үеийн бүсүүдийн хилийн заагийг тогтоосон тойм зургийг 1 дүгээр хавсралтаар, дэглэмийн үед хөдөлгөөнт эргүүлд ажиллах албан хаагч нарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хорио цээрийн дэглэмийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулан, хүч хэрэгслийг зөв хуваарилан оролцуулж, голомтын бүсийн заагт тасралтгүй ажиллагаатай хяналтын цэгийн байршлыг тогтоож, сэжигтэй бүсийн заагт хөдөлгөөнт эргүүл ажиллуулан мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавих зэргээр хорио цээрийн арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Гантулга)-д даалгасугай.

4.Хорио цээрийн дэглэмийн үед мал, амьтны гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврын дагуу мал эмнэлгийн цогц арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, халдварт өвчний цагийн байдлын мэдээллээр холбогдох газруудыг ханган ажиллахыг Мэргэжлийн багийн ахлагчид үүрэг болгосугай.

5.Хорио цээрийн дэглэм тогтоосон бүс нутагт малын шилжилт хөдөлгөөнийг бүрэн зогсоож, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хорио цээрийн дэглэм сахиулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Ч.Хорол)-д даалгасугай.

6.Мэргэжлийн анги, багийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа ажилтан, албан хаагч хорио цээрийн бүс дэх малчид, иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Г.Янжмаа)-д даалгасугай.

7.Хорио цээрийн бүс дэх малчин өрх, мал бүхий иргэдэд малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх , өвчний хор хөнөөлийн талаар ухуулан ойлгуулах, мал сүргээ хариулгатай байлгах, малчдын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, Сумын Онцгой комиссын шийдвэрийн талаар мэдээлэл хүргэх ажлыг багийн Засаг дарга (Ж.Пүрэвсүрэн)-д даалгасугай.

Alban hereg hutlult-026

622601185

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 25 өдөр Дугаар А/64 Өлзийт сум

Баяр наадмын зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ардын хувьсгалын 105, сум байгуулагдсаны 95 жилийн ойн баяр наадмын үйл ажиллагааг зохион байгуулахад 12,340,000 (арван хоёр сая гурван зуун дөчин мянга) төгрөгийг зарцуулсугай.

Үүнд:
Хурдан моринд -5,880,000
Шагайн харваанд- 727,000
Бөхийн барилдаанд- 1,450,000
Аж ахуй- 2,500,000
Шатахуун- 972,000
Бусад- 811,000

2.Сумын баяр наадамд зарцуулагдах 12,340,000 (арван хоёр сая гурван зуун дөчин мянга) төгрөгийг баяр наадмын зардалд зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601191

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 25 өдөр Дугаар А/85 Өлзийт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Жижиг дунд үйлдвэрийн газрын даргын 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хоршоодын хөгжлийн үнэлгээг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: О.Дэжидмаа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Гишүүд: Л.Мягмар (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)
Ц.Доржсэмбэ (1-р багийн Засаг дарга)
Ж.Пүрэвсүрэн (2 -р багийн Засаг дарга)
Л.Намдаг (3-р багийн Засаг дарга)
Н.Цэрэнтогтох (4-р багийн Засаг дарга)

2.Суманд бүртгэлтэй хоршоодын хөгжлийн үнэлгээг аргачлалын дагуу зохион байгуулан нэгтгэж, тайланг 2026 оны 07 дугаар сарын 25-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (О.Дэжидмаа)-д үүрэг болгосугай.

3.Хоршоодын хөгжлийг үнэлэх, хөгжлийн түвшин тогтоохтой холбогдох зардлыг Хоршоо хөгжүүлэх сангийн хүүгийн орлогын 60 хувиас зарцуулахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Дэжидмаа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601193

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 07 өдөр Дугаар А/67 Өлзийт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн цэцэрлэгийн гадна фасадын засвар үйлчилгээний зардалд гэрээний дагуу 79,698,429 (далан есөн сая зургаан зуун ерэн найман мянга дөрвөн зуун хорин ес) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГӨНЧИГ

Alban hereg hutlult-026

622601197

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 07 сарын 01 өдөр Дугаар А/68 Өлзийт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 1,3 дугаар багийн худгийн цооног гаргах ажлын зардалд гэрээний дагуу 32,000,000 (гучин хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээний зардлыг орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Ц.Энхтогорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601202

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 08 өдөр Дугаар А/69 Өлзийт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн "Дэлхийн адууны өдрийг тэмдэглэх тухай" 100 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/369 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Дэлхийн адууны өдрийг тэмдэглэх" арга хэмжээнд 5,000,000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,000,000 (хоёр сая) төгрөг, нэмэлт санхүүжилтээс 3,000,000 (гурван сая) төгрөгийг тус тус зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601207

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 08 өдөр Дугаар А/100 Өлзийт сум

"Дэлхийн адууны өдөр" арга хэмжээ
зохион байгуулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн "Дэлхийн адууны өдрийг тэмдэглэх тухай" 100 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/369 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Дэлхийн адууны өдөр" 2026 оны 07 дугаар сарын 13-ны өдөр Төв аймгийн Аргалант сумын "Хүй долоон худаг"-т зохион байгуулагдах тул тус арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий сумын ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2.Тус арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж бэлтгэл ажлыг сайтар хангаж нэгдсэн зохион байгуулалттай оролцоход ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601205

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 24 өдөр Дугаар А/71 Өлзийт сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1, 2.2, дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрүүл мэндийн төвийн дарга Г.Янжмаагийн 1-р улирлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 50 хувиар бодож олгосугай.

2.Урамшууллын тогтоосон хувь хэмжээг цалингийн санд багтаан олгохыг нягтлан бодогч (Н.Дааримаа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ө.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601212

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 04 өдөр Дугаар А/72 Өлзийт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 07/09 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан Эрүүл мэнд, боловсрол, соёл, төрийн захиргааны салбарын хүний нөөцийн хангалт, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрийн 4.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагч Баттулга овогтой Ананд Улсын техник, технологийн 27 дугаар олимпиадын "Автомашины загвар" төрөлд гуравдугаар байр эзэлж хүрэл медаль хүртсэн тул Боловсон хүчний хөтөлбөрийн хүрээнд 500,000 (таван зуун мянга) төгрөгийн шагнал олгосугай.

2.Дээрх зардлыг Сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулсан хүчин хөтөлбөрийн санхүүжилтээс зарцуулахыг нягтлан бодогч Ц.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601214

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 30 өдөр Дугаар А/73 Өлзийт сум

Сумын Батлан хамгаалах товчоо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 2.1.5, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2026 оны мн/04 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын "Дайчилгааны бэлэн байдлын төлөвлөгөө"-ний дагуу, сумын Батлан хамгаалах товчооны үндсэн байрыг Засаг даргын Тамгын газарт, бэлтгэл байрыг Ерөнхий боловсролын сургуулийн байранд, хэрийн байрыг Хүйсийн голын районд тус тус байгуулахаар тогтоосугай.

2.Сумын "Батлан хамгаалах товчоо"-ны орон тоог нэгдүгээр хавсралтаар, томилгоог хоёрдугаар хавсралтаар, холбоо мэдээлэл явуулах бүдүүвч, зарлан мэдээллийн дохиог гуравдугаар хавсралтаар, шаардлагатай материал хэрэгслийн товчоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Сумын "Батлан хамгаалах товчоо"-ны бүрэлдэхүүнийг томилгоожуулан тогтоосон хугацаанд тодотгох, сургалт, дадлага төлөвлөн зохион байгуулж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Гантулга)-д үүрэг болгосугай.

4. Сумын Батлан хамгаалах товчооны зардалд зарцуулах 3,900,000 (гурван сая есөн зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

62260121

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 03 өдөр Дугаар А/74 Өлзийт сум

Хүүхдийн цэцэрлэгийн гадна фасадын засварын ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна талын фасадны засварын ажлыг хүлээж авах ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсу...

Ажлын хэсгийн ахлагч: Л.Гантулга(Тамгын газрын дарга)
Гишүүд: О.Дэжидмаа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Л.Мягмар (Малын үржил, бүртгэл мэдээллийн асуу... хариуцсан мэргэжилтэн)
Д.Амарсанаа (Сургуулийн өмнөх боловсролын ба... эрхлэгч)
Б.Төмөрчулуун (Сургуулийн өмнөх боловсролын ба... туслах ажилт...

2. Дээрх ажлыг хууль тогтоомж, журмын дагуу зохион ба... хүлээж авахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026
622601220

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 08 сарын 05 өдөр Дугаар А/75 Өлзийт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 сарын 18-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг хүлээж авах ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Энхбаяр (Орлогч дарга)

Гишүүд: В.Аюушжав (Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)
Л.Жаргалсайхан (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)
Ш.Гэндэн (нярав)
Н.Цэрэнтогтох (4-р багийн Засаг дарга)

2. Дээрх ажлыг хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж хүлээж авахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Энхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГӨНЧИГ

Alban hereg hutlult-026
622601223

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 08 сарын 31 өдөр Дугаар А/76 Өлзийт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсэг Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох" журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өлзийт сумын нутаг дэвсгэрт байрлах 1 нэгж талбарыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг сумын газрын харилцаа, хамлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Цэнгэлмаа)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн "Газар эзэмшүүлэх тухай" А/76 дугаар захирамжийн хавсралтын 1 дүгээр мөрөн дэх Ж.Наранмандахтай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601225

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 08 сарын 09 өдөр Дугаар А/178 Өлзийт сум

Мал, амьтны гоц халдварт хонины цэцэг, Зооноз, архаг халдварт бруцеллёз өвчнүүдээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх 2026 оны төлөвлөгөөт дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/57 дугаар тушаал, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн "Бруцеллёз өвчний 2026 оны дархлаажуулалтын төлөвлөгөө батлах тухай" А/35 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай" А/134 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал эмнэлгийн газрын даргын 2026 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн "Гоц халдварт хонины цэцэг өвчнүүдээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах тухай" 37 дугаар тушаал, МЭЕГазрын даргын А/57 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт "Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх 2026 оны төлөвлөгөөт дархлаажуулалтыг зохион байгуулах тухай удирдамж"-ийн дагуу [illegible] хонь, хургыг бүрэн хамруулсугай.

2.Мал эмнэлгийн газрын даргын 2026 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн "Зооноз, архаг халдварт бруцеллёз өвчнүүдээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах тухай" 36 дугаар тушаал, МЭЕГазрын даргын А/35 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт "Бруцеллёз өвчний дархлаажуулалтын ажлын удирдамж"-ийн хүрээнд охин төл мал (тугал, хурга, ишиг)-ыг бүрэн хамруулсугай.

3.Дархлаажуулалтыг 2026 оны 08 дугаар сарын 10-ний өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл шуурхай зохион байгуулж дуусгахыг "Зосхангай" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч Ц.Виктор, "Баянханхал" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч Д.Чойжав, "Баяндалайн баялаг" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бага эмч Ц.Цэрэнханд эмч, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Alban hereg hutlult-026

622601229

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 09 сарын 15 өдөр Дугаар А/79 Өлзийт сум

Хязгаарлалтын дэглэмийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, 51 дүгээр зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1, 18.3, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Өлзийт сумын Мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Засаг даргын 2026 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/73 тоот захирамжийн дагуу 3 дугаар багийн нутаг Ташхай гэх газарт тогтоосон мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний хязгаарлалтын дэглэмийн хугацаанд тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх батлагдсан зааврын дагуу арга хэмжээг хэрэгжүүлсэн тул 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2.Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, халдваргүйжүүлэлт хийж, малчдад мэдээлэл зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангахыг Мал эмнэлгийн тасгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Содном-Иш)-т даалгасугай.

3.Хязгаарлалтын дэглэмийн үед ажилласан хяналтын цэг, албан тушаалтныг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж татан буулгахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Гантулга)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601233

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 09 сарын 15 өдөр Дугаар А/80 Өлзийт сум

Залуучуудын хөгжлийн зөвлөлийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, 13,14 дүгээр зүйл, Хөдөлмөр нийгмийн харилцааллын сайдын 2021 оны "Залуучууд хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай" А/72 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, хөгжил оролцоо, санал, санаачилгыг дэмжих тэдгээрийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах зорилгоор сумын "Залуучуудын хөгжлийн зөвлөлийг" дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: М.Ичинноров (Төрийн банкны эрхлэгч)
Гишүүд: Н.Халиун (Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан)
Ч.Ичинхорлоо (Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан)
А.Цэцгээ (Хүүхдийн цэцэрлэгийн туслах багш)
Ц.Цогзул (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтэн)
Н.Намуунцэцэг (Засаг даргын Тамгын газрын Улсын бүртгэгч)
Д.Мягмарсүрэн (Соёлын төвийн номын санч)
Б.Шүрэнцэцэг (ХААН банкны теллер)
П.Ариунболор (Сурагчдын төлөөлөл)
Д.Дорж (Малчин)

2.Залуучуудын зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажиллахыг Залуучуудын хөгжлийн дарга (М.Ичинноров)-д даалгасугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2025 оны Сумын Засаг даргын А/62 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026
622601231

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 09 сарын 02 өдөр Дугаар 2/81 Өлзийт сум

Малжуулах арга хэмжээний
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66.1 Сумын Засаг даргын Мөрийн хөтөлбөрийн 2.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Малжуулах арга хэмжээг зохион байгуулах, мал хүлээн авах иргэдийг сонгон шалгаруулах, мал олголтыг холбогдох журам, шийдвэрийн дагуу зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор малжуулах арга хэмжээг зохион байгуулах, үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга Засаг даргын орлогч Э.Энхбаяр

Гишүүдэд Хөдөлмөр эрхлэлт, халамж үйлчилгээ хариуцсан
Мэргэжилтэн Д.Цэрэндолгор
Малын эмч Э.Содном-Иш
2-р Багийн Засаг дарга Ж.Пүрэвсүрэн
3-р Багийн Засаг дарга Л.Намдаг
4-р Багийн Засаг дарга Н.Цэрэнтогтох

2.Ажлын хэсэг дараах үүргийг хэрэгжүүлсүгэй. Үүнд:

2.1.Малжуулах арга хэмжээний хүрээнд мал хүлээн авах иргэн, өрхийг холбогдох шалгуур, шаардлагын дагуу судалж, сонгон шалгаруулах.

2.2.Мал олгох иргэн, өрхийн бүртгэл, судалгааг үнэн зөв гаргаж, холбогдох баримт бичгийн бүрдүүлэх.

2.3.Малын төрөл, тоо хэмжээ, чанар, эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, хүлээн авах болон хүлээлгэн өгөх ажиллагааг зохион байгуулах.

2.4.Мал олголт,шижилт хөдөлгөөн, бүртгэл болон бусад холбогдох мэдээллийг тухай бүр баримтжуулах.

2.5.Малжуулах арга хэмжээний явц үр дүнгийн талаар удирдлагад танилцуулж, шаардлагатай мэдээлэл, тайланг гаргах.

3.Ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулах арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн гишүүн (Хөдөлмөр эрхлэлт, халамж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Засаг даргын орлогч)-т үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

62601235

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 09 сарын 04 өдөр Дугаар А/82 Өлзийт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дах заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 07/10 дугаар тогтоол, Сумын 2026 оны Хөгжлийн төлөвлөгөөний 2.29 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын малын үүлдэр угсааг сайжруулах, дутагдалтай хээлтүүлэгчийг худалдан авахад зориулан 7,000,000 (Долоон сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах Үзэмчин үүлдрийн хээлтүүлэгчийн үнэ 7,000,000 (Долоон сая) төгрөгийг Малын тоо толгойн албан татварын орлогоос зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601237

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 09 сарын 04 өдөр Дугаар А/23 Өлзийт сум

Золбин нохой устгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд Золбин нохой олширсноос иргэдийг урах, малчдын мал барьсан иргэдийн санал гомдлын дагуу золбин нохой устгалын ажлыг 2026 оны 09 дүгээр сарын 17-ноос 09 дүгээр сарын 18-ны хооронд зохион байгуулсугай.

2.Нохой устгалын зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Нохой устгалын зардал 632,500 (зургаан зуун гучин хоёр мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг сумын Нягтлан бодогч (Ц.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

4.Золбин нохойг булж устгахад ариутгал халдваргүйтгэл хийх, айл өрхүүдийн нохойг туулгажуулахыг "Баян ханхал" Мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн малын эмч (Д.Чойжив)-түүрэг болгосугай.

5.Золбин нохой устгалыг чанартай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны мэргэжилтэн (Л.Жаргалсайхан), 2 дугаар багийн Засаг дарга (Ж.Пүрэвсүрэн) -нарт үүрэг болгосугай.

6.Галт зэвсэгтэй ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж зааварчилгаа зөвлөмж өгч ажиллахыг Цагдаагийн хэсгийн төлөөлөгч дэслэгч (Ч.Хорол)- д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601241

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 24 өдөр Дугаар А/84 Өлзийт сум

Хөдөө аж ахуйн салбарын болон төв суурингийн 2026-2027 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн "Хөдөө аж ахуйн салбарын болон төв суурингийн 2026-2027 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээ"-ний тухай 56 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны 07 дүгээр сарын 30-ны А/489 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн салбарын болон төв суурингийн 2026-2027 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, шалгах, хүлээн авах ажлын [illegible]гийг 1 дүгээр, Хөдөө аж ахуйн болон төв суурингийн өвөлжилт, хаваржилтын [illegible]гэл хангах ажлын төлөвлөгөөг 2 дугаар, сум, багийн нөөцөд бэлтгэвэл зохих [illegible] тэжээл, малчдын түвшинд бэлтгэх өвс, гар тэжээл, хужир шүүний хэмжээг 3 дугаар [illegible]авсралтаар тус тус баталсугай.

2. Сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэхэд [illegible]аардагдах хөрөнгийг тухай бүрд нь шийдвэрлэж ажиллахыг сумын Засаг даргын [illegible]гын газрын дарга (Л.Гантулга), Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Дэжидм[illegible]нарт тус тус үүрэг болгосугай.

3.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу с[illegible]р зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг 2026 оны 10 дугаар сарын 10-ны дотор сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Энхбаяр[illegible]д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Э.ӨНЧИГ

Alban hereg hutlalt-026

6226012[illegible]43

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 09 сарын 25 өдөр Дугаар 01/35 Өлзийт сум

"Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, Сумын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний 2.2.30 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдааг 2026 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсугай.

2.Үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр дүгээр, шаардагдах зардлынтөсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3."Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн" худалдаанд зарцуулах 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutiult-026
622601253

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 09 сарын 30 өдөр Дугаар 09/86 Өлзийт сум

Цэргийн жинхэнэ албаны татлагыг
зохион байгуулах ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, аймгийн Засаг даргын 2026 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/548 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд 2026 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсугай.

2.Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Э.Энхбаяр (Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга Л.Гантулга (Тамгын газрын дарга)
Гишүүд В.Аюушжав (Хууль эрх зүйн мэргэжилтэн)
Л.Жаргалсайхан (Байгаль орчны мэргэжилтэн)
Д.Чулуундорж (Насан туршийн боловсролын [illegible]га зүйч)
С.Бадамдорж (Цагдаа)
М.Цэрэнханд (Архив бичиг хэргийн ажилтан)
Г.Янжмаа (Эрүүл мэндийн төвийн дарга)
Э.Долгормаа (Нийгмийн даатгалын ажилтан)
Ц.Алтангэрэл (Хүүхэд, гэр бүл хариуцсан мэргэжилтэн)
Ц.Доржсэмбэ (1 дүгээр багийн Засаг дарга)
Ж.Пүрэвсүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
Л.Намдаг (3 дугаар багийн Засаг дарга)
Н.Цэрэнтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)
О.Дэжидмаа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Э.Содном-Иш (Мал эмнэлгийн тасгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Ш.Гэндэн (нярав)
Я.Бумандолгор (үйлчлэгч)

2.Цэрэг татлагын комиссын гишүүдийн ажил үүргийн хуваарийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Alban hereg hutlult-026

622601247

Scanned with CamScanner

3.Эзлжит цэрэг татлагаар сумын Эрүүл мэндийн төвөөс эмч, мэргэжилтэн, сувилагч нарыг шинжилгээ авах, тоног төхөөрөмж дээр ажиллуулах удирдлагаар хангаж, аймгийн эмч нартай хамтран ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Г.Янжмаа)-д үүрэг болгосугай.

4.Цэрэг татлагын үйл ажиллагаанд зарцуулах 410,000 (Дөрвөн зуун арван мянга) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Ц.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг комиссын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 12 өдөр Дугаар А/87 Өлзийт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, сумын 2026 оны Хөгжлийн төлөвлөгөөний 6, 43 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Малчдын зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар батлалсугай.

2.Сумын малчдын зөвлөгөөнд зарцуулагдах 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг малын тоо толгойн албан татварын зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3.Малчдын зөвлөгөөнд оролцох малчдын бэлтгэл ажлыг хангаж ажлын хэсгийн гишүүдийн хийж гүйцэтгэх ажлыг томилгоожуулан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч сумын Засаг даргын орлогч (Э.Энхбаяр), нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Гантулга) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Doc: Alban hereg hutlult-zahiramj-026

622601249

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 12 өдөр Дугаар А/88 Өлзийт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ахмадын баяраар "Хүндэт аав" алдараа тэмдэглэж байгаа аавуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 1,395,000 (нэг сая гурван зуун ерэн таван мянга) төгрөг, баярын үйл ажиллагааны зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 2,395,000 (хоёр сая гурван зуун ерэн таван мянга) төгрөгийг сумын Засаг даргын нөөц болон Ахмадын сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601251

Scanned with CamScanner

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 15 өдөр Дугаар А/89 Өлзийт сум

Хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх,
эрт илрүүлэх үзлэгийг хамтран
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 28.10, 2026 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан А/254, А/255, дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Суманд төрийн үйлчилгээ үзүүлж байгаа Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн хамтын ажиллагааг хангаж, хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг 2026 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-нийг хүртэл зохион байгуулсугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601251

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 30 өдөр Дугаар А/90 Өлзийт сум

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын
гадна фасадны засварын ажилд
хяналт шалгалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралт "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна фасадны засварын ажилд хяналт тавих, үнэлгээ хийх ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Гантулга Тамгын газрын дарга
Гишүүд: Г.Хишигжаргал ИТХ-ын төлөөлөгч
Б.Төмөрчулуун иргэний төлөөлөл

2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна фасадны засварын ажилд 2026 оны 08 дугаар сарын 15-ны хяналт үнэлгээ хийж, дүгнэлт гарган Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Гантулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА Э.ГОНЧИГ

Alban hereg hutlult-026

622601260